Манай орны нутаг дэвсгэр дээр 128 зүйл уугуул хөхтөн тархан амьдардаг. Бидний судалгааны явцад хярс, үнэг, үлийн цагаан оготно зэрэг хөхтөн амьтдын ул мөр тэмдэглэгдэж байв. Төслийн талбайд Хярс үнэгний тархац өргөн хүрээнд байх магадлалтай. Төслийн талбайн хувьд Бага газрын чулуу байгалийн цогцолборт газартай ойролцоо байрладаг учир зарим хөхтөн амьтад болон махчин амьтдын шилжилт хөдөлгөөн дамжин өнгөрч болох талтай. Шувуудаас: Нөмрөг тас, Идлэг шонхор, Начин шонхор, Зээрд шонхор, Монгол ногтруу, Хөхвөр тагтаа, Хадны тагтаа, Бөвөөлжин өвөөлж, Монгол болжмор, Дагуур ятуу. Хөхтөн амьтдаас: Цагаан зээр, Бор туулай, Хотны үен, Цагаан үен, Мануул мий, Дэлдэн зараа, Цайвар сүүлт зурам, Говийн алагдаахай, Шивэр алагдаахай, Үлийн цагаан оготно. Махан идэшт агнуурын амьтдаас: Халздай дорго, Мануул мий, Хярс үнэг, Шар үнэг, Үмхий хүрэн, Эрээн хүрэн байна. Мэрэгч амьтдаас: Шар чичүүл, Монгол чичүүл, Хэргэлзий оготно, Орог зусаг бий. Тухайн бүс нутагт устаж буй хөхтөн амьтад үгүй.



ЗУРАГ 22. ХЯРСНЫ БААС



ЗУРАГ 237. ҮНЭГ



ЗУРАГ 24. ҮЛИЙН ЦАГААН ОГОТНЫ ҮҮР



ЗУРАГ 25. МОНГОЛ ГҮРВЭЛ

Төслийн талбайд бидний судалгааны явцад амьтад бүртгэгдээгүй ч тохиолдох магадлалтай амьтдын жагсаалтыг гаргав. Бусад хөхтөн амьтдын хувьд ажиглалтын хугацаанд ул мөр болон идэвхжил ажиглагдаагүй муутай байна. Дүрсийн буулгаж чадаагүй, холын зайнаас зүйлийг тодорхойлох боломжгүй шувууд болон мэрэгч зүйлүүд нилээдгүй байсан юм.

ХҮСНЭГТ 58. ТӨСЛИЙН ТАЛБАЙД ТОХИОЛДОЖ БОЛЗОШГУЙ АМЬТДЫН ЖАГСААЛТ

№	Монгол нэр	Шинжлэх ухааны нэр	Олон улсын үнэлгээ	Бүс нутгийн үнэлгээ	Улаан ном
1	Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>	VU	VU	Ховор
2	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	LC	EN	
Махан идэшт хөхтөн					
3	Хярс	<i>Vulpes corsac</i>	LC	EN	
4	Саарал чоно	<i>Canis lupus</i>	LC	NT	
5	Үнэг	<i>Vulpes vulpes</i>	LC	NT	
6	Мануул	<i>Felis manul</i>	NT	NT	
7	Халздай дорго	<i>Meles meles</i>	LC	LC	
8	Цагаан үен	<i>Mustela erminea</i>	LC	LC	
9	Хотны үен	<i>Mustela nivalis</i>	LC	LC	
10	Өмхий хүрэн	<i>Mustela eversmannii</i>	LC	LC	
11	Эрээн хүрнэ	<i>Vormela peregusna</i>	DD	LC	

Гар далавчтан					
12	Сахалт багваахай	<i>Myotis mystacinus</i>	LC	LC	
13	Дэлдэн зараа	<i>Hemiechinus auratus</i>	LC	LC	Улаан данс
Мэрэгч					
14	Гэрийн хулгана	<i>Mus musculus</i>			
15	Үлийн цагаан оготно	<i>Lasiopodomys brandti</i>	LC	LC	
16	Хэргэлзий оготно	<i>Microtus gregalis</i>	LC	LC	
17	Сохдой оготно	<i>Ellobius tancrei</i>	LC	LC	
18	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	LC	EN	
19	Хадны барагчин	<i>Alticola semicanus</i>	LC	LC	
20	Цомч шишүүхэй	<i>Allocricetulus curtatus</i>	LC	LC	
21	Сүүллэг шишүүхэй	<i>Cricetulus longicaudatus</i>	LC	LC	
22	Бүрдийн шишүүхэй	<i>Cricetulus sokolovi</i>	DD	LC	
23	Бор туулай	<i>Lepus tolai</i>		LC	
24	Цайвар сүүлт зурам	<i>Spermophilus pallidicauda</i>	LC	LC	
25	Бозлог зурам	<i>Spermophilus pallidicauda</i>	LC	LC	
26	Орог зусаг	<i>Phodopus campbelli</i>	LC	LC	
27	Элсний зусаг	<i>Phodopus roborovskii</i>	LC	LC	
28	Монгол чичүүл	<i>Meriones unguiculatus</i>	LC	LC	
29	Морин чичүүл	<i>Phombomys opimus</i>	LC	LC	
30	Говийн алагдаага	<i>Allactaga bullata</i>		LC	
31	Сибир алагдаага	<i>Allactaga sibirica</i>	LC	LC	
32	Тарвуу атигдаахай	<i>Cardiocranius paradoxus</i>	DD	DD	
33	Элсч савагдаахай	<i>Dipus sagitta</i>	LC	LC	
34	Монгол даахай	<i>Stylodipus andrewsi</i>	LC	LC	
35	Шаргал овол	<i>Eolagurus luteus</i>	LC	LC	
36	Тангад овол	<i>Eolagurus przewalskii</i>	DD	LC	
37	Дагуур огдой	<i>Ochotona dauurica</i>	LC	LC	
38	Үхэр огдой	<i>Ochotona pallasii</i>	LC	LC	
39	Говийн сармаахай	<i>Eptesicus gobiensis</i>	LC	LC	
40	Буурал сармаахай	<i>Vespertilio murinus</i>	LC	LC	
Хоёр нутагтан, мөлхөгчид					
41	Бамбай хоншоорт могой	<i>Glooydius halys</i>	--	LC	
42	Рашаан могой	<i>Coluber dione</i>	--	LC	

43	Монгол гүрвэл	<i>Eremias argus</i>	--	LC
----	---------------	----------------------	----	----

Бүс нутгийн хэмжээнд үнэлснээр “устаж болзошгүй” зүйл 3, “ховордож болзошгүй” зүйл 3, “эмзэг” зүйл 1 байна. “Тахь ресурс” ХХК-ийн нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Т-1 талбайн тусгай зөвшөөрлийн талбай орчим тохиолдох боломжтой хөхтөнөөс бүс нутгийн хэмжээнд Устаж болзошгүй зүйлүүд болох Цагаан зээр, Хярс, Монгол тарвага нар байна. Эдгээр төрөл зүйлүүдэд төслийн үйл ажиллагааны явцад хөнөөл учруулахыг хатуу хориглох бөгөөд дараах хамгааллын арга хэмжээг Монгол улсад мөрдөн ажиллаж байна:

ХҮСНЭГТ 59. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ДАХЬ ЗАРИМ ЗҮЙЛ ХӨХТНИЙ ХАМГААЛЛЫН ХЭЛБЭР

Зүйлийн нэр	Ховордлын шалтгаан	Хамгааллын хэлбэр
Монгол тарвага	Дотоодын болон гадаадын зах зээлд гаргахаар мах, арьс, ардын эмнэлэгт ашиглах зорилгоор агнадаг. Тарваганы тос кортикостероне ² их хэмжээгээр агуулдаг ба хүүхэд, амьтанд хүнсний нэмэлт тэжээл байдлаар хэрэглэдэг, мөн түлэнхий, хөлдөлт, анемия, сүрьеэ, арьсны өвчинд хэрэглэж ирсэн уламжлалтай ⁷ . Өнгөрсөн зууны 1906 оноос 1994 оны хооронд Монголд нийт 104,2 сая тарваганы арьс олзворложээ ⁸ . Сүүлийн үед хийгдсэн агнуурын судалгааны мэдээгээр тухайн жилд тогтоосон агнуурын хяналтын тооноос даруй гурав дахин их тарваганы арьс арилжаалагдсан тоо баримт байгаа бөгөөд хууль бусаар 2004 онд бэлтгэсэн 117,000 гаруй тарваганы арьсыг улсын орлого болгожээ (Zahler нар, 2004). Тахал өвчин дэлгэрэх нь тоо толгойн хорогдолын шалтгааны нэг бөгөөд тарвага агнах явцад хүн тарваган тахлын нянгаар халдварлагдгийг тогтоосон учраас устгахыг оролддог ⁹ . Гэсэн хэдий ч популяцийн тоо толгой буурах хэрээр тахал гарах давтамж буурдаг байна.	Байгаль Орчны Яамны сайдын тушаалаар 2005, 2006 онд орон даяар тарваганы агнуурыг бүрэн хориглосон. Урьд нь популяцийн тоо толгойноос хамааран наймдугаар сарын 10-аас аравдугаар сарын 15 хүртэлх хугацаанд тарвага агнахыг хуулиар зөвшөөрдөг байсан (БОЯ, 2005). Мөн түүнчлэн орон нутгийн засаг захиргаанд дөрвөн жил тутам судалгаа хийх, энэ зүйлийг хамгаалахын тулд тухайн газар нутгийн агналтыг хаах эрхийг хуулиар олгосон байна. Агнуурын гол нутагт (зөвшөөрөгдсөн тохиолдолд) агнуурын үйл ажиллагаа явуулдаг компанийн өөрсдийн хөрөнгөөр нь жил бүр судалгаа хийлгэсэн байх ёстой (Wingard, Zahler, 2006). Монгол тарваганы тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан. Байгаль Орчны Яамны сайдын тушаалаар 2005, 2006 онд орон даяар тарваганы агнуурыг бүрэн хориглосон. Урьд нь популяцийн тоо толгойноос хамааран наймдугаар сарын 10-аас аравдугаар сарын 15 хүртэлх хугацаанд тарвага агнахыг хуулиар зөвшөөрдөг байсан (БОЯ, 2005). Мөн түүнчлэн орон нутгийн засаг захиргаанд дөрвөн жил тутам судалгаа хийх, энэ зүйлийг хамгаалахын тулд тухайн газар нутгийн агналтыг хаах эрхийг хуулиар олгосон байна. Агнуурын гол нутагт (зөвшөөрөгдсөн тохиолдолд) агнуурын үйл ажиллагаа явуулдаг компанийн өөрсдийн хөрөнгөөр нь жил бүр судалгаа хийлгэсэн байх ёстой (Wingard, Zahler, 2006). Монгол тарваганы тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.

⁷ Адъяа, 2000

⁸ Батболд, 1996

⁹ Batbold, 2002

Хярс	<p>Үслэг арьс, мах зэрэг бүтээгдэхүүн нь бага үнэтэй ч хараа хяналтгүй агнуур газар авсаар байна. Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онуудад үлийн цагаан оготны (<i>Lasiopodomys brandti</i>) тоо толгойг зохицуулахад хэрэглэж буй Бромадиолоне химийн хорт бодисонд дам өртөж хорогдох нь бий. Гэсэн хэдий ч энэ үйл ажиллагаа одоогоор зогссон ч бусад зүйлд нөлөөлсөөр байна (Н. Батсайхан, аман мэдээ). Байгалийн нөөцийн олборлолтын (уул уурхай) идэвхтэй үйл ажиллагаа өссөнөөс амьдрах орчны хомсдол бий болж байна. Гэрийн нохойнд дайруулахаас гадна галзуу өвчинд нэлээд өртөмтгий (Гептнер нар, 1967).</p>	<p>Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрсөн (БОЯ, 2005). Засгийн газрын тогтоолоор олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 55 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Хярсны тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.</p>
Цагаан зээр	<p>Албан ёсны агнуурын тооноос хууль бус агнуурын хэмжээ давж, өргөн цар хүрээгээр агнаж байгаа нь ховордлын гол шалтгаан юм (Lkhagvasuren, Milner-Gulland, 1997). Milner-Gulland, Lkhagvasuren (1998) нарын гаргасан агнуурын загвар нь нэг сая толгой бүхий популяциас жилд 60,000 толгойг агнах даацтай гэж үзсэн ч одоогоор агнасан хэмжээ нь 300 гаруй хувиар давж байна</p>	<p>Агнуурыг 1932 оноос хяналттай явуулж байсан ба бүс нутгийн хэмжээнд албаны хэрэгцээнд агнах тоо хэмжээг тогтоож ирсэн байна. Жил бүрийн есдүгээр сарын 1-нээс арванхоёрдугаар сарын 1 хүртэл агнахыг хуулиар зөвшөөрсөн (БОЯ, 2005). 1995 оны Агнуурын тухай хуулиар цагаан зээрийг техникээр агнахыг хориглосон ба хэрэв хууль бусаар агнавал нэг бүрийн үнэ нь 30-40 ам.доллар гэж тогтоосон.</p>

Иймд “Тахь ресурс” ХХК нь (i) амьтдын амьдрах орчныг алдагдуулахгүй байх, (ii) төслийн ажилчид хууль бус ан агнуур хийлгэхгүй байх, урьдчилан сэргийлэхэд онцгойлон анхаарч ажиллах, (iii) тус төсөлд зэрлэг амьтдад хор хөнөөлтэй, гэмтээх хашаа хайс байршуулахгүй байх (iv) тусгай зөвшөөрлийн талбайн гадна хор хөнөөл учруулахгүй байх шаардлагатай.



Шувуу

Монгол орны хэмжээнд нийт 502 зүйл шувуу нүүдлийн, хагас нүүдлийн болон суурин байдлаар амьдардаг. Төслийн талбай орчмын бүсэд нийт 110 орчим зүйл шувуу багтаж



байгаа. Үүний дийлэнхи хувь нь нүүдлийн болон улиралын онцлогтой байршдаг зүйл шувууд юм. Энэ орчны бүс нутагт тохиолдох шувуудын бүс нутгийн болон олон улсын үнэлгээгээр анхааралд өртөхөөргүй байна. Олон улсын үнэлгээгээр эмзэг ангилалд 2 зүйл, устаж болзошгүй ангилалд 2 зүйл, ховордож болзошгүй ангилалд 6 зүйл байна.

ЗУРАГ 608. ХЭЭРИЙН БҮРГЭД

№	Түгээмэл нэр	Шинжлэх ухааны нэршил	Бүс нутгийн үнэлгээ	Олон улсын үнэлгээ
1	Отгот шунгуур	<i>Podiceps cristatus</i>	АӨ	АӨ
2	Хөх дэглий	<i>Ardea cinerea</i>	АӨ	АӨ
3	Гангар хун	<i>Cygnus cygnus</i>	АӨ	АӨ
4	Ногоохон нугас	<i>Anas crecca</i>	АӨ	АӨ
5	Зэрлэг нугас	<i>Anas platyrhynchos</i>	АӨ	АӨ
6	Анхидал ангир	<i>Tadorna tadorna</i>	АӨ	АӨ
7	Халбага нугас	<i>Spatula clypeata</i>	АӨ	АӨ
8	Цагаан хөмсөгт нугас	<i>Spatula querquedula</i>	АӨ	АӨ
9	Шовтгор алаг нугас	<i>Anas acuta</i>	АӨ	АӨ
10	Зээрд нугас	<i>Mareca penelope</i>	АӨ	АӨ

11	Бор нугас	<i>Mareca strepera</i>	АӨ	АӨ
12	Улаан хүзүүт шумбуур	<i>Aythya ferina</i>	АӨ	Э
13	Гээгт шумбуур	<i>Aythya fuligula</i>	АӨ	АӨ
14	Ооч ёл	<i>Gwpaetus barbatus</i>	Э	ХБ
15	Саарал хулд	<i>Circus cyaneus</i>	АӨ	АӨ
16	Сохор элээ	<i>Milvus migrans</i>	АӨ	АӨ
17	Нөмрөг тас	<i>Aegyptus monachus</i>	АӨ	ХБ
18	Хималайн хажир	<i>Gyps himalayensis</i>	АӨ	ХБ
19	Талын сар	<i>Buteo rufinus</i>	АӨ	АӨ
20	Ойн сар	<i>Buteo buteo</i>	АӨ	АӨ
21	Морин харцага	<i>Accipiter nisus</i>	АӨ	АӨ
22	Начин шонхор	<i>Falco tinnunculus</i>	АӨ	АӨ
23	Зээрд шонхор	<i>Falco naumanni</i>	АӨ	АӨ
24	Цармын бүргэд	<i>Aquila chrysaetos</i>	АӨ	АӨ
25	Тарважи бүргэд	<i>Aquila nipalensis</i>	АӨ	УБ
26	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>	АӨ	АӨ
27	Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	УБ	Э
28	Шууман шонхор	<i>Falco subbuteo</i>	АӨ	АӨ
29	Амарын шонхор	<i>Falco amurensis</i>	АӨ	АӨ
30	Дагуур ятуу	<i>Perdix dauurica</i>	АӨ	АӨ
31	Өвөгт тогоруу	<i>Arthropoides virgo</i>	АӨ	АӨ
32	Нарийн хиазат	<i>Charadrius dubius</i>	АӨ	АӨ
33	Азийн сүвээ цагаан	<i>Pluvialis fulva</i>	АӨ	АӨ
34	Умардын хавтгаалж	<i>Vanellus vanellus</i>	АӨ	ХБ
35	Халзан түнжүү	<i>Fulica atra</i>	АӨ	АӨ
36	Шар түрүүт элсэг	<i>Calidris ruficollis</i>	АӨ	ХБ
37	Одой элсэг	<i>Calidris minuta</i>	АӨ	АӨ
38	Алаг хайргач	<i>Arenaria interpres</i>	АӨ	АӨ
39	Тэнгисийн хиазат	<i>Charadrius alexandrinus</i>	АӨ	АӨ
40	Дорнын хиазат	<i>Charadrius veredus</i>	АӨ	АӨ
41	Зэвэн хиазат	<i>Charadrius leschenaultii</i>	АӨ	АӨ
42	Сүүл элсэг	<i>Calidris acuminata</i>	АӨ	АӨ
43	Хадуур элсэг	<i>Calidris ferruginea</i>	АӨ	ХБ
44	Темминскийн элсэг	<i>Calidris temminckii</i>	АӨ	АӨ
45	Савар элсэг	<i>Calidris subminuta</i>	АӨ	АӨ
46	Хар хөгчүү	<i>Tringa erythropus</i>	АӨ	АӨ
47	Улаан хөлт хөгчүү	<i>Tringa totanus</i>	АӨ	АӨ
48	Үхэр хөгчүү	<i>Tringa nebularia</i>	АӨ	АӨ
49	Шугуйн хөгчүү	<i>Tringa glareola</i>	АӨ	АӨ
50	Цагаан сүүлт хөгчүү	<i>Tringa ochropus</i>	АӨ	АӨ
51	Хайргын хөгчүү	<i>Actitis hypoleucos</i>	АӨ	АӨ
52	Бүрдний хөгчүү	<i>Tringa stagnatilis</i>	АӨ	АӨ
53	Замбын хараалж	<i>Gallinago stenura</i>	АӨ	АӨ
54	Шөвгөн хараалж	<i>Gallinago gallinago</i>	АӨ	АӨ
55	Монгол цахлай	<i>Larus argentatus</i>	АӨ	АӨ
56	Хүрэн толгойт цахлай	<i>Larus ridibundus</i>	АӨ	АӨ
57	Буурал хараалзай	<i>Chlidonias leucopterus</i>	АӨ	АӨ
58	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>	АӨ	АӨ
59	Хөхвөр тагтаа	<i>Columba livia</i>	АӨ	АӨ
60	Монгол ногтруу	<i>Syrhaptus paradoxus</i>	АӨ	АӨ

61	Эгэл шар шувуу	<i>Bubo bubo</i>	АӨ	АӨ
62	Эгэл хөхөө	<i>Culculus canorus</i>	АӨ	АӨ
63	Дорнын хүүргэнэ	<i>Streptopelia orientalis</i>	АӨ	АӨ
64	Хотны бүгээхэй	<i>Athene noctua</i>	АӨ	АӨ
65	Холтсон гоётуул	<i>Jynx torquilla</i>	АӨ	АӨ
66	Бөвөөлжин өвөөлж	<i>Upupa epops</i>	АӨ	АӨ
67	Хондлой цагаан ураацай	<i>Apus pacificus</i>	АӨ	АӨ
68	Хурын ураацай	<i>Apus apus</i>	АӨ	АӨ
69	Монгол болжмор	<i>Meloncorypha mongolica</i>	АӨ	АӨ
70	Асрын алтанхараацай	<i>Hirundo rustica</i>	АӨ	АӨ
71	Боролзой болжмор	<i>Alauda arvensis</i>	АӨ	АӨ
72	Согсоот болжмор	<i>Galerida cristata</i>	АӨ	АӨ
73	Дэрсний жиргэмэл	<i>Calandrella cheleensis</i>	АӨ	АӨ
74	Хээрийн шийхнүүхэй	<i>Anthus richardi</i>	АӨ	АӨ
75	Хөх цэгцгий	<i>Motacilla alba</i>	АӨ	АӨ
76	Уулын цэгцгий	<i>Motacilla cinerea</i>	АӨ	АӨ
77	Шар цэгцгий	<i>Motacilla flava</i>	АӨ	АӨ
78	Харзны шийхнүүхэй	<i>Anthus spinoletta</i>	АӨ	АӨ
79	Бөртөг шийхнүүхэй	<i>Anthus hodgsoni</i>	АӨ	АӨ
80	Годлевскийн шийхнүүхэй	<i>Anthus godlewskii</i>	АӨ	АӨ
81	Үнсэн дунхай	<i>Lanius excubitor</i>	АӨ	АӨ
82	Тольт дунхай	<i>Lanius isabellinus</i>	АӨ	АӨ
83	Ухаа дунхай	<i>Lanius cristatus</i>	АӨ	АӨ
84	Сибирийн хайруулдай	<i>Prunella montonella</i>	АӨ	АӨ
85	Хадны жижир	<i>Monticola saxatilis</i>	АӨ	АӨ
86	Бүжимч чогчиго	<i>Oenanthe isabellina</i>	АӨ	АӨ
87	Цөлийн чогчиго	<i>Oenanthe deserti</i>	АӨ	АӨ
88	Мяраан чогчиго	<i>Pied wheatear</i>	АӨ	АӨ
89	Адууч чогчиго	<i>Oenanthe oenanthe</i>	АӨ	АӨ
90	Өнгөлүүрт гургалдай	<i>Luscinia calliope</i>	АӨ	АӨ
91	Дагуур галсүүлт	<i>Phoenicurus auroreus</i>	АӨ	АӨ
92	Улаан гүеэт хөөндэй	<i>Turdus ruficollis</i>	АӨ	АӨ
93	Цөлийн зэржигэнэ	<i>Sylvia nana</i>	АӨ	АӨ
94	Бүхт дууч шувуу	<i>Phylloscopus fuscatus</i>	АӨ	АӨ
95	Цагаан хэвэлж хөмрөг	<i>Emberiza pallasi</i>	АӨ	АӨ
96	Шар элэгт нөмрөг	<i>Emberiza aureola</i>	Э	УБ
97	Монгол алтанжигүүр	<i>Bucanetes mongolicus</i>	АӨ	АӨ
98	Улаан бор бужирга	<i>Carduelis flavirostris</i>	АӨ	АӨ
99	Хадны боршуу	<i>Petronia petronia</i>	АӨ	АӨ
100	Хээрийн бор шувуу	<i>Passer montanus</i>	АӨ	АӨ
101	Орончийн бор шувуу	<i>Passer domesticus</i>	АӨ	АӨ
102	Хар хэрээ	<i>Corvus corone</i>	АӨ	АӨ
103	Турлиах хэрээ	<i>Corvus frugilegus</i>	АӨ	АӨ
104	Улаан хошуут жунгаа	<i>Red billed chough</i>	АӨ	АӨ
105	Хондон ангир	<i>Tadorna ferruginea</i>	АӨ	АӨ
106	Эвэрт болжмор	<i>Eremophila alpestris</i>	АӨ	АӨ
107	Талын жиргэмэл	<i>Calandrella brachydactyla</i>	АӨ	АӨ
108	Хон хэрээ	<i>Corvus corax</i>	АӨ	АӨ
109	Монгол божирог	<i>Pyrgilauda davidiana</i>	АӨ	АӨ
110	Цасны богшоодой	<i>Montifringilla nivalis</i>	АӨ	АӨ

(АӨ – Анхааралд өртөхөөргүй; ХБ – Ховордож болзошгүй; УБ – Устаж байгаа; МД – Мэдээлэл дутмаг; Э – Эмзэг; УБо – Устаж болзошгүй; ҮБ– Үнэлэх боломжгүй)

13.5 Ургамлан нөмрөгийн мониторингийн судалгаа:


Ургамалжилын Судалгааны Арга Зүй

Ургамалжилтын мониторингийн хээрийн судалгааг 2025 оны 09 дүгээр сарын 20-21 нд хийж гүйцэтгэсэн.

Судалгааны зорилго: Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагааны явцад ургамлан бүрхэвчийн өөрчлөлт, доройтол ажиглагдаж байгаа эсэх, мөн хайгуулын талбайн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход ургамлын мониторингийн судалгааны зорилго оршино.

Судалгааны арга зүй: Мониторингийн ажлын хүрээнд хяналт шинжилгээний тогтоосон 10 цэг тус бүрт ургамлын бичиглэл хийн, зүйлийн бүрдлийг тодорхойлон, өөрчлөлт доройтлыг тогтоож, биомассын хэмжилт хийсэн. Геоботаникийн бичиглэл хийхийн тулд тухайн газарт 10x10 м², 1x1 м² раменскийн тор татаж тус талбайд зүйл тус бүрээр нь бичиглэл хийж, хээрийн судалгааны мэдээ материал цуглуулан боловсруулалт хийсэн.

Геоботаникийн бичиглэлд:



ЗУРАГ 9. УРГАМЛЫН ХЭЭРИЙН СУДАЛГАА АВЧ БУЙ БАЙДАЛ

Зүйлийн бүтэц, бүрэлдэхүүн: Ургамал бүлгэмдэл бүрт ургасан ургамлын нийт зүйлийг хээрийн судалгаагаар бүртгэж, фото зургийг авж тодорхойлох боломжгүй зүйлийг бичиглэлийн хуудсанд кодлон бичээд, тус зүйлийн хатаамал хийж, лабораторид

тодорхойлсны дараа нэрийг нь бичсэн. Ургамал тодорхойлохдоо И.В. Грубов (2008), Н. Өлзийхутаг (1985), болон бусад (Flora of China, 2019) эх сурвалжийг ашиглав. Ургамлынзүйлийг “Монгол орны биологийн олон янз байдал: ургамал, мөөг, бичил биетний зүйлийн жагсаалт”-нд зааснаар (Ургамал нар, 2019) нэрлэсэн.

Арви: Ургамалжлын зүйлийн арвид О.Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.

Тусгаг бүрхэц: Тусгагийн бүрхэц (цаашид бүрхэц хэмээв) нь аливаа биетийн газрын гадаргуу дээрх тусгалын проекц юм. Бүлгэмдлийн нийт бүрхэц, халцгай газар, хагд болон зүйл тус бүрийн бүрхэцийг 1 м х 1 м хэмжээтэй тор ашиглан хувиар үнэлж, гэрэл зургаар баталгаажуулав.

Өсөлт: Ургамлын өсөлтийг тодорхойлохын тулд өндрийг сантиметрийн хэмжээт шугамаар газрын хөрснөөс дээш 0 см-ийн өндөрт 3 удаагийн давталттай хэмжсэн.

Ургац: Зүйлийн бүрэлдэхүүн цөөн, ургамалжил шигүү биш байхад 1м² хэмжээгээс дээж авах тохиромжтой¹⁰. Ургамлыг зүйл тус бүрээр газрын гадаргын түвшинд хайчлан авч, цаасан уутанд хийнэ. Хээрээс цуглуулсан дээжээ тасалгааны температурт 2-3 долоо хоног хатаана. Харьцангуй хуурай жинг 0.01-0.05 гр-ийн нарийвчлалтай электрон жингээр тодорхойлно.




ЗУРАГ 10. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ДЭЭЖ БЭЛТГЭЖ БУЙ БАЙДАЛ

¹⁰ Геоботаник УБ 2005

ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН УРГАМАЛЖЛЫН ОНЦЛОГ

Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын талбай нь цөлөрхөг хээр болон хээрийн бүсэд хамаарна.



ЗУРАГ 11. Т-1 ХАЙГУУЛЫН ТАЛБАЙН УРГАМЛЫН НӨМРӨГИЙН СУДАЛГААНЫ ЦЭГҮҮД

Хуурай хээр

Монголын хээр бол Европ дахь Унгар (Мажар) улсын нутагт пушт хэмээх хээрээс Дорнод Ази дахь Манжуурын хээр хүртэл үргэлжлэх хээрийн дорнодын хэсэгт оршдог, Хээрт хуурайсаг олон наст дэгнүүлт ба үндэслэг ишт үетэн, элдэв өвслөг ургамал зонхилдог. Монголын хээрийн бусдаас ялгагдах онцлог нь хуурайсаг сөөг болох хэд хэдэн зүйл харгана, агь (өлчир шарилж) зэрэг сөөг, сөөгөнцөр ихтэй байдаг. Хээрийн бүсэд үржил сайтай нунтаг карбонаттай ба карбонатгүй, нунтаг карбонаттай хүрэн, заримдаа элсэнцэр цайвар хүрэн хөрстэй, хотгор хонхор дагаж марц, мараатай байдаг байна. Хээрийн бүс нь Дорнод Монгол, Дундад Халхын тэгш өндөрлөг, өргөн уудам тал газрыг хамарч баруун тийш нарийссаар Хангайн нурууны өврийн нам уулсын бэлээр Хан Хөхий өмнөд бэл хүртэл нарийн зурвасаар эх нуруудын хотгор хүрч замхарна.

Ихэнх нутгаар нь 130-250мм тунадас унадаг тул ихэнхдээ гануу, ургамал ургах хугацаа 150-170 хоног үргэлжилнэ. Монголын хээрт хялгана-хазаарганат, хиаг-хялганат, түнгэ-өлөн-агьт, хялгана-хазааргана-агьт, хялгана-агьт, хялгана-таанат, дөрвөн үетэнт, зөр-өвст, алаг өвс-үетэнт, харганат хээр зонхилно.

Цөлөрхөг хээр

Энэ бүс нь Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нэлээд эрт үүсч бий болсон, биеэ даасан үүсэлтэй, зүйлийн бүрэлдэхүүн, бүтцийн хувьд давтагдашгүй өвөрмөц бөгөөд Төв Азидаа эндемикт тооцогддог. Их нуруудийн хотгор, Олон нуурын хөндий, Дорноговийн нам өндөрлөг, Говь Алтайн нурууг хамарна. Цөлийн хээр буюу заримдаг цөлийн ихэнх нутаг нь цөлийн хээрийн ба хээржүү цөлийн бор хөрстэй байх боловч хойд хэсгээрээ нунтаг карбонаттай цайвар хүрэн хөрстэй. Энэ бүсийн бараг бүх хэсэгт байдаг хотгор, хотос нь хужир марц, мараа бүхий хөрстэй, тойромтой байдаг билээ.

Цөлийн хээрийн бүсэд жилдээ 100-125мм тунадас унадаг, ургамал ургах хугацаа 170-190 хоног үргэлжлэх ба ихэвчлэн гандуу байна. Унах тунадас болон хөрсний чийг дутмаг тул цөлийн хээрийн ургамал хээрийнхээс илүү ганд тэсвэртэй, хуурайсаг шинжтэй байдаг. Хуртай зун түр зуурын борооны чийгэн нэг ба хоёр наст ургамлууд ихээр ургаж синузи үүсгэнэ. Ганд тэсвэртэй ургамлын гадаргуу үсээр өвч хучигдаж ус бага ууршуулах, хэт халалтаас хамгаалагдсан байдаг.

Олон зүйл ургамал навчгүй болж фотосинтез явуулах, амьсгалах үүргийг нэг наст залуу ногоон найлзуур гүйцэтгэнэ. Зарим ургамал ус хуримтлуулах зохилдлоготой шүүслэг болсон байдаг. Ургамлын ганд тэсвэрлэх эдгээр зохилдого цөлийн бүс рүү шилжихэд улам тод илэрнэ. Цөлийн хээрийн бүс нь жижиг дэгнүүлт үетэн болох өдлөг хялганууд (*Stipa glareosa*, *S. gobica*, *S. klementzii*) тархацаар тодорхойлогдоно¹¹.

Ургамалжлын онцлог, бүлгэмдлийн өнөөгийн төлөв байдал

T1-25-01 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар Гурвантойром (N: 46°6'34" E: 104°56'36")

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт ухаа гүвээт талд байрлалтай тус бүлгэмдэл нь улаан харгана-говийн хялгана-монгол сонгинот бүлгэмдэлтэй. Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*), Улаан харгана (*Caragana leucophloea*), Ширэг өлөн (*Carex duriuscula*), Крыловын хялгана (*Stipa krylovii*), Одой харгана (*Caragana pugnata*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), Өлчир шарилж (*Artemisia frigida*), зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 8-15 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Одой харгана (*Caragana pugnata*), 2-р үеллийг 10-40 см өндөр бүхий Ширэг өлөн (*Carex duriuscula*), Крыловын хялгана (*Stipa krylovii*) зэрэг ургамлууд, 3-р үеллийг 0-10 см өндөр бүхий Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*) зэрэг ургамлууд тус тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 20 % байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 8 зүйл ургамалтай. 9-р сарын байдлаар 0.8 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.

¹¹ Ургамал судлал хээрийн дадлага 2017 он



ЗУРАГ 12. Т1-25-01 ТАЛБАЙ

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-таана

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 25%, хайрга чулуун бүрхэвч 10 %, хагдан бүрхэвч 20 %, ил хөрс 75% орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8-15см



ЗУРАГ 13. Т1-25-01 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 6121. Т1-25-01 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-таана	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Sp</i>	2	<i>Caragana pygmaea</i>
	<i>Stipa krylovii</i>	<i>Cop2</i>	8	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Caragana leucophloea</i>	<i>Sol</i>	3	<i>Artemisia frigida</i>
	<i>Allium mongolicum</i>	<i>Cop2</i>	7	

Т1-25-02 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Гурвантойром (N: 46⁰3'60" E: 104⁰56'42" 1460м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт гүвээт тал байрлалтай тус бүлгэмдэл н, улаан харгана-говийн хялгана-дэрвээн хазааргана бүлгэмдэлтэй. Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*), Улаан харгана (*Caragana leucophloea*), Өлчир шарилж (*Artemisia frigida*), Данхар хавьсгана (*Scorzera capito*) Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), Согсоолж (*Heteropappus*), Царс навчит ангалзуур



ЗУРАГ 14. Т1-25-02 ТАЛБАЙ

(*Lagochilus ilicifolius*) зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 8-12см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Улаан харгана (*Caragana leucophloea*), 2-р үеллийг 10-40 см өндөр Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*) бүхий зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд, 3-р үеллийг 0-10 см өндөр бүхий Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд тус тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 25% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 10 зүйл ургамалтай. 9 дугаар сарын байдлаар 1.8 ц/га ургацтай. 9-р сарын 2 дүгээр 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-жигжиг үетэнт

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 25 %, хайрга чулуун бүрхэвч 5 %, хагдан бүрхэвч 27 %, ил хөрс 70 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8-12 см



ЗУРАГ 15. Т1-25-02 ТАЛБАЙ ӨНӨӨГИЙН ТӨРХ


ХҮСНЭГТ 62. Т1-25-03 ТАЛБАЙН УРГАМАЛ БҮЛГЭМДЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-жижиг үетэнт	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Cop3</i>	12	<i>Caragana pygmaea</i>
	<i>Stipa krylovii</i>	<i>Cop2</i>	6	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Neopallasia pectinata</i>	<i>Sol</i>	3	<i>Artemisia frigida</i>
	<i>Caragana leucophloea</i>	<i>Rr</i>	4	<i>Scorzonera capito</i>
				<i>Plantago minuta</i>
				<i>Chenopodium glaucum</i>
				<i>Lagochilus ilicifolius</i>

Т1-25-03 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Гурвантойром (N: 46⁰4’8” E: 104⁰48’24” 1410м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт гүвээний хярд байрлалтай тус бүлгэмдэл нь улаан харгана-говийн хялгана-монгол сонгинот бүлгэмдэлтэй. Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*), Улаан харгана (*Caragana leucophloea*), Согсоолж (*Heteropappus*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), *Salsola spp* зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 8-12 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Одой харгана (*Caragana pugnata*), Улаан харгана (*Caragana leucophloea*), 2-р үеллийг 10-40 см өндөр Монгол сонгино



ЗУРАГ 16. Т1-25-03 ТАЛБАЙ

(*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*) 3-р үеллийг 40+ см Гялгар дэрс (*Neotrinia splendens*) бүхий зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд, зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд тус тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 20% байх бөгөөд 10 метр квадратад

дунджаар 9 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 0.5 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээний тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-жигжиг үетэнт

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 20%, хайрга чулуун бүрхэвч 20%, хагдан бүрхэвч 20 %, ил хөрс 75% орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8-12см



ЗУРАГ 17. Т1-25-03 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 22. Т1-25-03 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-таана	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Sol</i>	3	<i>Caragana pygmaea</i>
	<i>Stipa krylovii</i>	<i>Cop1</i>	5	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Caragana leucophloea</i>	<i>Sol</i>	4	<i>Agropyron cristatum</i>
	<i>Allium mongolicum</i>	<i>Cop3</i>	8	<i>Artemisia frigida</i>
				<i>Salsola spp</i>
				<i>Caragana stenophylla</i>

Т1-25-04 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Гурвантойром талбай (N: 45°06'35" E: 104°48'19" 1440м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт гүвээний хярд байрлалтай тус бүлгэмдэл нв улаан харгана-говийн хялгана-монгол сонгинот бүлгэмдэлтэй. Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica*)

subsp. glareosa), Улаан харгана (*Caragana leucophloea*) зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 10-15 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 2 үеллийг үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Одой харгана (*Caragana pugnata*), Улаан харгана (*Caragana leucophloea*), 2-р үеллийг 10-40 см өндөр Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. glareosa) бүхий зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд, тус тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 23% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 6 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 0.3 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.



ЗУРАГ 18. Т1-25-04 ТАЛБАЙ

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-жигжиг үетэнт

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 23%, хайрга чулуун бүрхэвч 5 %, хагдан бүрхэвч 23 %, ил хөрс 70 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 10-15 см



ЗУРАГ 19. Т1-25-04 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 23. Т1-25-04 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /	Т1-25-05
Улаан харгана-хялгана-жигүүр үетэн	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Cop1</i>	3	<i>Caragana pygmaea</i>	
	<i>Stipa krylovii</i>	<i>Sp</i>	7	<i>Convolvulus ammannii</i>	
	<i>Caragana leucophloea</i>	<i>Sp</i>	5	<i>Agropyron cristatum</i>	
	<i>Allium mongolicum</i>	<i>Cop2</i>	8	<i>Artemisia frigida</i>	

талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Цавчир талбай (N: 45⁰41'16" E: 104⁰57'55" 1440м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт гүвээт тал байрлалтай тус бүлгэмдэл нь улаан харгана-говийн хялгана-жигжиг үетэнт бүлгэмдэлтэй. Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*), Улаан харгана (*Caragana leucophloea*) зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 8 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Одой харгана (*Caragana pugnata*), Улаан харгана (*Caragana leucophloea*), 2-р үеллийг 10-40 см өндөр Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*) бүхий зэрэг



ЗУРАГ 20. Т1-25-05 ТАЛБАЙ

ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд, 3-р үеллийг 8 см өндөр бүхий Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд тус тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 35% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 7 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 2.3 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-жигжиг үетэнт

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 35 %, хайрга чулуун бүрхэвч 5 %, хагдан бүрхэвч 30 %, ил хөрс 55 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8см



ЗУРАГ 21. Т1-25-05 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ


Хүснэгт 24. Т1-25-05 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-жигжиг үетэнт	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Cop3</i>	20	<i>Caragana pygmaea</i>
	<i>Stipa caucasica subsp. glareosa</i>	<i>Cop2</i>	9	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Caragana leucophloea</i>	<i>Sol</i>	3	<i>Agropyron cristatum</i>
				<i>Artemisia frigida</i>

Т1-25-06 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Цавчир талбайн (N: 45⁰41'7" E: 104⁰52'9" 1400м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт ухаа гүвээт талд байрлалтай тус бүлгэмдэл нь улаан харгана-жижиг үетэнт бүлгэмдэлтэй Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Ширэг өлөн (*Carex duriuscula*), Үслэг мананхамхаг (*Grubovia dasyphylla*), Крыловын хялгана (*Stipa krylovii*), Одой харгана (*Caragana pugnata*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), Саман ерхөг (*Agropyron cristatum*), Өлчир шарилж (*Artemisia frigida*), Улаан харгана (*Caragana leucophloea*) зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 8см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр



ЗУРАГ 22. Т1-25-06 ТАЛБАЙ

(босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Одой харгана (*Caragana pugnata*), 2-р үеллийг 10-40 см өндөр бүхий Ширэг өлөн (*Carex duriuscula*), Крыловын хялгана (*Stipa krylovii*) зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд, 3-р үеллийг 0-10 см өндөр бүхий Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Үслэг мананхамхаг (*Grubovia dasyphylla*), Үхэр шүлхэй (*Neopallasia pectinata*) тус тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 25% байх бөгөөд 10 метр квадратад

дунджаар 8 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 0.5 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-жигжиг үетэнт

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 25 %, хайрга чулуун бүрхэвч 5 %, хагдан бүрхэвч 25 %, ил хөрс 75 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8 см



ЗУРАГ 23. Т1-25-06 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 25. Т1-25-06 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-жигжиг үетэнт	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Cop3</i>	12	<i>Caragana pygmaea</i>
	<i>Carex duriuscula</i>	<i>Cop2</i>	5	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Grubovia dasyphylla</i>	<i>Rr</i>	1	<i>Agropyron cristatum</i>
	<i>Stipa krylovii</i>	<i>Sol</i>	3	<i>Artemisia frigida</i>
	<i>Caragana leucophloea</i>	<i>Sol</i>	4	

Т1-25-07 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Цавчир талбай (N: 45°37'55" E: 104°44'58" 1310м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт ухаа гүвээт тал, гүвээний хажуу энгэрт байрлах говийн хялгана-үндсэрхэг сонгинот тус бүлгэмдэл нь малын хөл, хээрийн замаар элэгдэл, эвдрэлд өртсөн.

Үндсэрхэг сонгино (*Allium polyrhizum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *Glareosa*, Улаан харгана (*Caragana leucophloea*) зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 8-12 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг үүсгэнэ. Хүн, мал амьтны нөлөө, хээрийн замын нөлөөгөөр элэгдэл эвдрэлд өртсөн. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц



ЗУРАГ 24. Т1-25-07 ТАЛБАЙ

дунджаар 20% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 3-5 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 0.6 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-таана

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 20 %, хайрга чулуун бүрхэвч 15 %, хагдан бүрхэвч 15 %, ил хөрс 80 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8-12 см



ЗУРАГ 25. Т1-25-07 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 26. Т1-25-07 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Говийн хялгана-үндсэрхэг сонгинот	<i>Stipa caucasica</i> subsp. <i>glareosa</i>	<i>Sol</i>	5	
	<i>Allium polyrhizum</i>	<i>Sol</i>	8	
	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Cop1</i>	5	
	<i>Caragana leucophloea</i>		5	

Т1-25-08 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Цавчир талбай (N: 45⁰39'45.0" E: 104⁰53'15.3" 1415м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн бүсэд говийн шал дахь улаан бударгана-дэрст бүлгэмдэлтэй. Улаан бударгана (*Reaumuria soongarica*) зонхилж Говийн хялгана (*Stipa saucasica* subsp. *glareosa*), Гялгар дэрс (*Neotrinia splendens*), Сибирь хармаг (*Nitraria sibirica*), Харлаг өмхий-өвс (*Peganum nigellastrum*), нар дагалдан ургана. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 8-12 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 2 үеллийг үүсгэнэ. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий



ЗУРАГ 26. Т1-25-08 ТАЛБАЙ

тусгагийн бүрхэц дунджаар 20 % байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 9 зүйл ургамалтай. 9 дугаар сарын байдлаар 0.7 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүлгэмдлийн зүйлүүд фенологийн хувьд ургал үе дээр байв.

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-жигжиг үетэнт

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 20 %, хайрга чулуун бүрхэвч 10 %, хагдан бүрхэвч 20 %, ил хөрс 73 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8-12 см



ЗУРАГ 27. Т1-25-08 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 27. Т1-25-08 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-жигжиг үетэнт	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>sp</i>	3	<i>Caragana pygmaea</i>
	<i>Carex duriuscula</i>	<i>sp</i>	2	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Stipa krylovii</i>	<i>Rr</i>	4	<i>Agropyron cristatum</i>
	<i>Neopallasia pectinata</i>	<i>Sol</i>	9	<i>Artemisia frigida</i>
	<i>Caragana leucophloea</i>	<i>Sol</i>	4	<i>Peganum nigellastrum</i>
	<i>Eragrostis minor</i>			

Т1-25-09 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Цавчир талбай (N: 45°45'27.14" E: 104°29'23.86" 1373м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт гүвээний хярд байрлалтай тус бүлгэмдэл нв улаан харгана-говийн хялгана-дэрст бүлгэмдэлтэй. Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*), Улаан харгана (*Caragana leucophloea*), Гялгар дэрс (*Neotrinia splendens*), Үслэг мананхамхаг (*Grubovia dasyphylla*) зэрэг зүйлүүд зонхилж, тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 10-17 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг



ЗУРАГ 28. Т1-25-09 ТАЛБАЙ

үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Одой харгана (*Caragana pugnata*), Улаан харгана (*Caragana leucophloea*), 2-р үеллийг 10-40 см өндөр Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*), Гялгар дэрс (*Neotrinia splendens*) бүхий зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд, 3-р үеллийг 10-15 см өндөр бүхий Үслэг мананхамхаг (*Grubovia dasyphylla*) зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд тус

тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 25% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 10 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 0.8 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-таана

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 25 %, хайрга чулуун бүрхэвч 5 %, хагдан бүрхэвч 20 %, ил хөрс 80 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 10-15 см



ЗУРАГ 29. Т1-25-09 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 28. Т1-25-09 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-дэрст	<i>Cleistogenes squarrosa</i>			<i>Caragana pygmaea</i>
	<i>Carex duriuscula</i>	Cop3	3	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Grubovia dasyphylla</i>	Cop1	6	<i>Agropyron cristatum</i>
	<i>Stipa krylovii</i>			<i>Artemisia frigida</i>
	<i>Neotrinia nigellastrum</i>	Cop2	6	
	<i>Caragana leucophloea</i>	Cop2	6	
	<i>Eragrostis minor</i>			

T1-25-10 талбайн ургамлын бичиглэл

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар- Цавчир талбай (N: 45⁰42'9" E: 104⁰35'21" 1460м)

Бүлгэмдлийн бүтэц: Цөлөрхөг хээрийн тойрогт гүвээний хярд байрлалтай тус бүлгэмдэл нв улаан харгана-говийн хялгана-жигжиг үетэнт бүлгэмдэлтэй. Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*), Улаан харгана (*Caragana leucophloea*) зэрэг зүйлүүд зонхилон тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 08-12 см ба энэхүү бүлгэмдэл сөөг болон өвслөг ургамлын гэсэн 2 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 3 үеллийг үүсгэнэ. Үүнд 1-р үеллийг сөөгөн ташинга Одой харгана (*Caragana pugnata*), Улаан харгана (*Caragana leucophloea*), 2-р үеллийг 10-40 см өндөр Монгол сонгино (*Allium mongolicum*), Говийн хялгана (*Stipa caucasica* subsp. *glareosa*) бүхий зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд, 3-р үеллийг 0-10 см өндөр бүхий Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*) зэрэг ургамлуудын ургал болон үржлийн найлзуурууд тус тус тархана. Хүн, мал амьтны нөлөө 3 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 18% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 7 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 0.8 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүх зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үе дээр байв.



ЗУРАГ 30. Т1-25-10 ТАЛБАЙ

Цэгийн гадаргын ерөнхий байдал: ухаа гүвээт тал

Бүлгэмдлийн хэв шинж: улаан харгана-хялгана-жигжиг үетэнт

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 18 %, хайрга чулуун бүрхэвч 5 %, хагдан бүрхэвч 20 %, ил хөрс 80 % орчим байна.

Ургамлын дундаж өндөр: 8-12 см



ЗУРАГ 31. Т1-25-10 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

Хүснэгт 29. Т1-25-10 талбайн ургамал бүлгэмдлийн бүрэлдэхүүн

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м ² /	Арви	Бүрхэц	Дагалдах зүйл /10 м ² /
Улаан харгана-хялгана-жигжиг үетэнт	<i>Cleistogenes squarrosa</i>	<i>Cop3</i>	8	<i>Caragana pygmaea</i>
	<i>Stipa krylovii</i>	<i>Cop2</i>	6	<i>Convolvulus ammannii</i>
	<i>Caragana leucophloea</i>	<i>Sp</i>	4	<i>Agropyron cristatum</i> <i>Artemisia frigida</i>

Хүснэгт 30. Тэмдэглэсэн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ач холбогдол, аж ахуйн бүлэг


№	Түгээмэл нэр	Шинжлэх ухааны нэр	Аж ахуйн бүлэг
1	Дэрвээн хазааргана	<i>Cleistogenes squarrosa</i>	Үетэн
2	Ширэг өлөн	<i>Carex duriuscula</i>	Улалж
3	Үслэг мананхамхаг	<i>Grubovia dasyphylla</i>	Алаг өвс
4	Крыловын хялгана	<i>Stipa krylovii</i>	Үетэн
5	Үхэр шүлхэй	<i>Neopallasia pectinata</i>	Алаг өвс
6	Улаан харгана	<i>Caragana leucophloea</i>	Сөөг
